

ОНОШИЛГОО ХЭМЖИЛ ЗҮЙН ЛАБОРАТОРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ДОТООД  
АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЙЛАН  
ТОВЧЛОЛ/

2019.05.17

Улаанбаатар хот

ИНЕГ-ын даргын 2019 оны 05 дугаар сарын 07-ны өдөр баталсан ИНЕГ-ын харьяа ОХЗЛ-ийн үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалт хийх тухай удирдамжийн хүрээнд тус нэгжийн үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалтыг хийлээ.

Батлагдсан удирдамжийн дагуу ИНЕГ-ын ДАА-ны ахлах аудитор Л.Жаргалсайхан, санхүүгийн хяналтын мэргэжилтэн Б.Болормаа, Ц.Цацрал нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2019 оны 05 дугаар сарын 08-ны өдрөөс 2019 оны 05 дугаар сарын 18-ны өдрийг хүртэлх хугацаанд дотоод аудитыг хийсэн.

ИНЕГ-ын даргын баталсан удирдамжийн хүрээнд ОХЗЛ-ийн 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2019 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хугацааны захиргаа, хүний нөөцийн үйл ажиллагаа, үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм, журам болон дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, үр дүнгийн гэрээний болон төсөв төлөвлөгөөний гүйцэтгэл, цалин хөлсний бодолт, олголт зэргийг үндсэн баримт нотолгоонд тулгуурлан шалгах, зарим эргэлзээтэй зүйлүүд дээр холбогдох албан тушаалтнаас тайлбар, тодруулга аван ажиллалаа.

ИНЕГ-ын даргатай байгуулсан 2018 оны үр дүнгийн гэрээний хэрэгжилт 96.8 хувьтай, 96.3 оноогоор А буюу "Маш сайн" үнэлгээтэй дүгнэгдсэн.

Барилгын дээврийн ажилд 2018 онд урсгал засварыг хийж, өнгө үзэмжийг сайжруулж, ажилчдын ажиллах нөхцөлийг хангасан.

ЗУГ-аас ажилчдын хувийн хэргийн бүрдүүлэлт, шинэчлэлт, тэдгээрийн мэдээллийг хүний нөөцийн програмд оруулсан байдал хангалтгүй. Харин ОХЗЛ-ийн лаборант, бичиг хэргийн ажилтан ажилчдын хувийн хэргийг хуулбарлан, бүрдүүлэлтийг сайн хийсэн байгаагаас үлгэр авах нь зүйтэй. Ажлын цагийн бүртгэлийг буруу гаргасан.

Цалин хөлс, түүнтэй холбоотой бусад мөнгөн тооцоогоор ажилласан хоногийг буруу тооцож гаргаснаас цалингийн тооцоо, үр дүнгийн нэмэгдэл хөлсний тооцоо, удаан жилийн тооцоо зэргээр илүү олголт гарсан.

Цалинтай чөлөөг ажилласан хоногт оруулж тооцсоноос хоолны үнийн хөнгөлөлт илүү олгосон.

ИНЕГ-ын харьяа нэгжүүдэд үзүүлсэн үйлчилгээний орлогыг бүртгэлд тусгадаггүй, зардлын зүйл ангийг буруу илэрхийлж бүртгэсэн.

Бусад байгууллагатай хийсэн зарим гэрээний төлбөрийг хэрхэн тооцох нь бүрхэг, дуусах хугацаа тодорхойгүй, гэрээний дугаар тавиагүй байна.

Аудитын шалгалтын үр дүнд гарсан алдаа, дутагдлын засаж, залруулах талаар тус лабораторид нийт 9 зөвлөмж өгсөн болно.

ДОТООД АУДИТЫН АЛБА